

МОНЛОЖИСТИКС ХОЛДИНГ ХХК-ИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2023 оны 11 сарын 29 өдөр

№: 23/УЗ/34

Улаанбаатар хот

Хувьцаа эргүүлэн худалдан авч, халааслах тухай

Монгол улсын Компанийн тухай хуулийн 49 дүгээр зүйлийн 49.1, 49.2 дахь заалт, 55 дугаар зүйлийн 55.2 дахь заалт, 76 дугаар зүйлийн 76.1.7 заалт, Санхүүгийн зохицуулах хорооны 2021 оны 6 дугаар сарын 11-ний өдрийн 225 тоот тогтоолоор батлагдсан “Үнэт цаасны бүртгэлийн журам”-ын 8 дугаар зүйл, “Монложистикс Холдинг” ХХК (“Компани”)-ийн 2023 оны 11 сарын 29-ний өдрийн ээлжит бус хурлын санал хураалтын дүнг тус тус үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Хувьцааны үнэ тогтворжуулах хөтөлбөрийн хүрээнд хоёрдогч зах зээлийн арилжаанаас хувьцаа эргүүлэн худалдан авах нөхцөлийг 1 дүгээр хавсралт ёсоор баталсугай.
2. Үнийн тогтвортой байдлыг хангах зорилгоор хувьцаа эргүүлэн худалдан авах ажиллагааг Андеррайтерын үйлчилгээ үзүүлэх эрх бүхий этгээдээр дамжуулан, холбогдох хууль тогтоомж, гэрээ хэлцлийн дагуу шаардлагатай арга хэмжээ авч ажиллахыг Гүйцэтгэх захирал (Г.Хишигбат)-д үүрэг болгосугай.
3. Энэхүү тогтоол батлагдсантай холбогдуулан Санхүүгийн зохицуулах хороо, Монголын хөрөнгийн бирж ТӨХК, Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв зэрэг холбогдох эрх бүхий байгууллагад мэдээллийг хүргүүлж, хувьцааг эргүүлэн худалдан авч, халааслахтай холбоотой мэдээллийг хууль тогтоомжид заасны дагуу нийтэд мэдээлж ажиллахыг Төлөөлөн Удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга (Э.Нарангарвуу) –д –д даалгасугай.
4. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн Удирдах зөвлөлийн дарга (Л.Ганзоригт) –д даалгасугай.

ТУЗ-ИЙН ДАРГА



Л.ГАНЗОРИГТ

№ Компани өөрийн хувьцааг эргүүлэн худалдаж авах нөхцөл

- | | | |
|---|--|---|
| 1 | Эргүүлэн худалдаж авах хувьцааны нийт тоо, ширхэг | 2,968,941 ширхэгээс ихгүй буюу нийтэд нээлттэй санал болгохоор зарласан хувьцааны 5 хувиас ихгүй. |
| 2 | Эргүүлэн худалдан авах захиалгын дээд үнэ | 160 төгрөг |
| 3 | Эргүүлэн худалдан авах үйл ажиллагаа үргэлжлэх хугацаа | 2024 оны 5 дугаар сарын 27-ны өдрийг хүртэл |
| 4 | Эргүүлэн худалдан авах захиалга хийх нөхцөл | Хувьцааны үнэ анх гаргасан үнээс 15 хувь болон түүнээс дээш хэмжээнд унах |
| 5 | Эргүүлэн худалдаж авах хувьцааны үнийн дүнгийн дээд хэмжээ | 500,000,000 (таван зуун сая) төгрөгийн үнийн дүнгээр худалдан авах ажиллагааг хэрэгжүүлнэ. |
| 6 | Хувьцаа худалдан эх үүсвэр | Эргүүлэн худалдаж авах хувьцааны үнийн дүнгийн дээд хэмжээ болох 500 сая төгрөгийн 60% - Монложистикс Холдинг ХХК
Үлдэх 40%- Монложистикс Экүйпменте ХХК |

Нэмэлт тайлбар: Компани нь Хувьцааны үнэ тогтворжуулах хөтөлбөрийн хүрээнд өөрийн хувьцаагаа эргүүлэн худалдан авч байгаа бөгөөд хувьцааны үнэ нь анх гаргасан үнээс 15 хувь болон түүнээс дээш хэмжээнд унаагүй тохиолдолд эргүүлэн худалдан авах ажиллагааг хийж гүйцэтгэхгүй.

**“МОНЛОЖИСТИКС ХОЛДИНГ” ХХК-ИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ**

2023/11/29

Дугаар:23/ТУЗ/34

Улаанбаатар хот

Хуралд оролцсон	Л.Ганзоригт, Б.Тэлэнгэд, Э.Оюунбилэг, Г.Цэрэнпүрэв, Г.Хишигбат Б.Энхтүвшин, С.Сайнбат, С.Энх-Амгалан		
Хуралдсан хаяг	Монгол улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, бага тойруу, Ж.Самбуугийн гудамж-32, БлюМон төв, 10 давхар, Хурлын өрөө		
Хурал хүчин төгөлдөрт тооцогдсон ирц	89%	Шийдвэр хүчин төгөлдөрт тооцогдсон ирц	89%
Хуралдсан огноо	2023 оны 11 дүгээр сарын 29-ний өдөр		
Хурлаар хэлэлцсэн асуудал	Хувьцаа эргүүлэн худалдан авч, халааслах тухай		
Шийдвэрлэсэн нь	<p>Монгол улсын Компанийн тухай хуулийн 49 дүгээр зүйлийн 49.1, 49.2 дахь заалт, 55 дугаар зүйлийн 55.2 дахь заалт, 76 дугаар зүйлийн 76.1.7 заалт, Санхүүгийн зохицуулах хорооны 2021 оны 6 дугаар сарын 11-ний өдрийн 225 тоот тогтоолоор батлагдсан “Үнэт цаасны бүртгэлийн журам”-ын 8 дугаар зүйл, “Монложистикс Холдинг” ХХК (“Компани”)-ийн 2023 оны 11 сарын 29-ний өдрийн ээлжит бус хурлын санал хураалтын дүнг тус тус үндэслэн ТОГТООХ НЬ:</p> <ol style="list-style-type: none"> 1. Хувьцааны үнэ тогтворжуулах хөтөлбөрийн хүрээнд хоёрдогч зах зээлийн арилжаанаас хувьцаа эргүүлэн худалдан авах нөхцөлийг 1 дүгээр хавсралт ёсоор баталсугай. 2. Үнийн тогтвортой байдлыг хангах зорилгоор хувьцаа эргүүлэн худалдан авах ажиллагааг Андеррайтерын үйлчилгээ үзүүлэх эрх бүхий этгээдээр дамжуулан, холбогдох хууль тогтоомж, гэрээ хэлцлийн дагуу шаардлагатай арга хэмжээ авч ажиллахыг Гүйцэтгэх захирал (Г.Хишигбат)-д үүрэг болгосугай. 3. Энэхүү тогтоол батлагдсантай холбогдуулан Санхүүгийн зохицуулах хороо, Монголын хөрөнгийн бирж ТӨХК, Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв зэрэг холбогдох эрх бүхий байгууллагад мэдээллийг хүргүүлж, хувьцааг эргүүлэн худалдан авч, халааслахтай холбоотой мэдээллийг хууль тогтоомжид заасны дагуу нийтэд мэдээлж ажиллахыг Төлөөлөн Удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга (Э.Нарангарвуу) –д даалгасугай. 4. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн Удирдах зөвлөлийн дарга (Л.Ганзоригт) –д даалгасугай. 		

**ТЭМДЭГЛЭЛТЭЙ ТАНИЛЦАЖ, ТУЗ-ИЙН ХУРЛААР ХЭЛЭЛЦЭН ШИЙДВЭРЛЭСЭН
АСУУДЛЫГ БАТАЛГААЖУУЛСАН**

ТУЗ-ИЙН ДАРГА

Л.ГАНЗОРИГТ



ТУЗ-ИЙН ГИШҮҮД

Б.ЭНХТҮВШИН

Э.ОЮУНБИЛЭГ

Г.ЦЭРЭНПҮРЭВ

Г.ХИШИГБАТ

Б.ТЭЛЭНГЭД

С.САЙНБАТ

С.ЭНХ-АМГАЛАН

A collection of handwritten signatures in black and blue ink, arranged vertically. The signatures are stylized and correspond to the names listed on the right side of the page. The blue ink signature at the top is the most prominent.